



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар A/80

Бор-Өндөр сум

Мал, амьтны, шимэгчтэх өвчнөөс
эмчлэн сэргийлэх арга хэмжээг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.13, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дугаар зүйлийн 21.3.1, 21.3.21 дэх заалт, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны A/180 дугаар Захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Б.Болормаа

Мал эмнэлгийн тасгийн дарга

Нарийн бичгийн дарга

Р.Цэндсүрэн

Тархвар зүйч

Гишүүд

И.Энхтуяа

У.Пүрэвсүрэн

Д.Мөнгөнтуяа

Ч.Саруулмөнх

Б.Мөнх-Оргил

Н.Отгонбилэг

Ц.Бат-Эрдэнэ

Ц.Төртүвшин

Бор-Өндөр 1 дүгээр Багийн Засаг дарга

Холбоо 2 дугаар багийн Засаг дарга

Бумбат 3 дугаар багийн Засаг дарга

Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга

Хүйх 5 дугаар багийн Засаг дарга

Өлгий 6 дугаар багийн Засаг дарга

“Ноён Зүлэгт” ХХК МЭҮН-ийн захирал

“ЭнТэЧи” ХХК МЭҮН-ийн захирал

2. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг хавсралтаар баталж, тус арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 22-ний өдрөөс эхлэн зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Б.Болормаа)-д үүрэг болгосугай.

3. Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээг орон нутагтаа графикт хугацаанд нь шуурхай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн Малын эмч (Ц.Бат-Эрдэнэ, Ц.Төртүвшин) нарт, Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, зохион байгуулах, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж дүнг нэгтгэж танилцуулахыг Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн (Б.Болормаа, Р.Цэндсүрэн)-д тус тус даалгасугай.


4. Мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчин, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүй малчин мал бүхий иргэд, холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Б.Болормаа)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Ууганжаргал), ажлын гүйцэтгэлийг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Р.Цэндсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ



Бор-Өндөр сумын Засаг даргын
2025 оны 09 сарын 09 өдрийн
А/20 Захирамжийн 1 дүгээр хавсралт

БОР-ӨНДӨР СУМЫН ХЭМЖЭЭНД 2025 ОНД ШИМЭГЧТЭХ ӨВЧНӨӨС ЭМЧЛЭН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Шимэгчтэхийн арга хэмжээ / мян.тол/															
Д/д	Аж ахуй нэгжийн нэр	Угаалга				Туулгалт				Боловсруулалт				Нийт	
		үхэр	хонь	ямаа	бүгд	үхэр	хонь	ямаа	нохой	бүгд	үхэр	хонь	ямаа		бүгд
1	'Энтэчи'ХХК МЭҮН	0.5	5.5	7.0	13.0	0.4	2.0	2.0	0.1	4.5	0.2	2.0	2.0	4.2	21.7
2	'Ноён зүлэгт'ХХК МЭҮН	0.8	5.0	6.5	12.3	0.4	3.0	3.0	0.1	6.5	0.2	3.0	3.0	6.2	25.0
	Бүгд	1.3	10.5	13.5	25.3	0.8	5.0	5.0	0.2	11.0	0.4	5.0	5.0	10.4	46.7

ТӨЛӨВЛӨГӨӨ НЭПТЭСЭН:
УЛСЫН БАЙЦААГЧ Б.БОЛОРМАА
ТАРХВАР ЗҮЙЧ Р.ЦЭНДСҮРЭН